




ДАМЖУУЛАХ

Сүлжээ



2005 оноос эрхлэн гаргав.

ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

№1 (164) 2026

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН 2026 ОНЫ ЗОРИЛТ

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь 2026 онд дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллана.

1. Удирдлага, стратеги, бодлогын уялдаа холбоог бэхжүүлж, компанийн дунд болон урт хугацааны хөгжлийн зорилтыг оновчтой хэрэгжүүлэх /21 ажил/
2. Санхүүгийн чадавх, тогтвортой байдлыг хангаж, зардлын хяналт, хөрөнгийн удирдлага, нөөцийн үр ашигтай ашиглалтыг дээшлүүлэх /13 ажил/
3. Хүний нөөцийн чадавхыг хөгжүүлж, мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлэх /14 ажил/
4. Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлж, үйл ажиллагааны сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх /9 ажил/
5. Дижитал шилжилт, автоматжуулалтыг эрчимжүүлж, үр ашиг, шуурхай байдлыг нэмэгдүүлэх /мэдээллийн сан, цахимжуулалт /12 ажил/
6. Инноваци, ногоон эрчим хүчний шилжилт, шинэ технологийн нэвтрүүлэлтийг дэмжиж, үйл ажиллагааны бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх (судалгаа хөгжил, төлөвлөлт) /11 ажил/
7. Хамтын ажиллагаа, ил тод байдлын түвшинг дээшлүүлэх /6 ажил/
8. Дамжуулах сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, эрчим хүчний аюулгүй байдлыг баталгаажуулах /19 ажил/
9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг сайжруулж, аюулгүй ажлын орчныг бүрдүүлэх /6 ажил/
10. Засвар үйлчилгээний ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, чанарыг сайжруулж, тоноглолын найдвартай байдлыг хангах /13 ажил/

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



XVII жарны “Сүрээр дарагч” хэмээгч гал морин жилийн сар шинийн босгон дээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Техникийн бодлогын хэлтсийн Горим тооцооны инженер Б.Амарбаясгалан ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН-оор шагнагдлаа.

Мөн Эрчим хүчний сайдын 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар Эрчим хүчний салбарын 2025 оны шилдэг инженер техникийн ажилтан, албан хаагчдыг тодруулж, Хангайн бүсийн салбарын Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны

ашиглалт, шуурхай үйлчилгээний инженер Д.Алтанхуяг “Шилдэг инженер”-ээр шалгарч, “Шилдэг мастер”-аар Говийн бүсийн салбарын Засварын албаны дэд станцын засварын мастер Э.Алтанширээ, Төвийн бүсийн салбарын Баруунхараа дэд станцын ээлжийн монтёр Д.Чулуунбат “Шилдэг ажилтан”-аар шалгарлаа.

Эрчим хүчний салбарын, инженер техникийн ажилтнуудыг ажил үйлсээрээ манлайлан шилдгээр тодорсонд компанийн хамт олны нэрийн өмнөөс халуун баяр хүргэж, ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсье.

НҮҮР-2

- УИХ-ЫН ГИШҮҮН С.ЦЭНГҮҮН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-Д АЖИЛЛАЛАА

НҮҮР-4

- ТӨВИЙН БҮСИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙН ӨВЛИЙН ГОРИМД АЧААЛАЛ ОРГИЛДОО ХҮРЭВ

НҮҮР-6

- ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД СТАНЦУУДЫН ШИНЭЧЛЭЛ БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН АЖЛУУД ЭРЧИМТЭЙ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

НҮҮР-8

- ТӨВИЙН БҮСИЙН САЛБАРЫН 60 ЖИЛИЙН ОЙГОО ТЭМДЭГЛЭЛЭЭ

НҮҮР-10

- 2025-2026 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭГ ЦУВРАЛ БОЛГОН ХҮРГЭХ НЬ

НҮҮР-12

- 90/10” ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ ШИНЭЭР БАТЛАГДЛАА

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

УИХ-ЫН ГИШҮҮН С.ЦЭНГҮҮН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-Д АЖИЛЛАЛАА



УИХ гишүүн С.Цэнгүүн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр компанийн үйл ажиллагаатай танилцав.

Уулзалтын үеэр эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангахын тулд 500 кВ-ын дамжуулах шугам барих, дэд станцуудыг алсын удирдлагатай, бүрэн автоматжуулсан системд шилжүүлэх боломжийг судалж байгаа бөгөөд энэ нь орон тоог оновчтой болгох, бүтээмжийг нэмэгдүүлэх ач холбогдолтойг инженерүүд онцлов.

С.Цэнгүүн гишүүн эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудад улсын төсвийн хөрөнгө оруулалт оруулах шаардлагатай, дэд станцын шинэчлэл, дамжуулах шугамын өргөтгөл, автоматжуулалтын төслүүдийг шуурхай хэрэгжүүлэх зэрэг зарим арга хэмжээний талаар санал солилцлоо.



Гуравдугаар байр Зүүн-Өмнөд бүсийн салбар

СПОРТЫН ТАВАН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Компанийн Үйлдвэрчний эвлэлийн хороо нь ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон спортын таван төрөлт уралдаан тэмцээнийг зохион байгуулдаг.

Энэ жилийн тэмцээнд шинээр байгуулагдсан Баруун бүсийн салбар болон Алтай-Улиастайн салбарын багууд оролцсоноор илүү онцлогтой болж, хамт олны эв нэгдэл, спортын идэвхийг улам бүр өрнүүлээ.

Багийн нийлбэр дүнгээр Улаанбаатар салбар тэргүүлж шилжин явах цомын эзэн болсон бол Говийн бүсийн салбар, Зүүн-Өмнөд бүсийн салбар удаалсан байна.

Энэхүү уламжлалт спортын тэмцээн нь хамт олны эв нэгдлийг бэхжүүлэхийн зэрэгцээ байгууллагын соёлыг хөгжүүлэх уламжлал болсон арга хэмжээ юм.




Нэвдүгээр байр Улаанбаатар салбар



Хоёрдугаар байр Говийн бүсийн салбар

Уламжлалт тэмцээний сагсан бөмбөгийн эрэгтэй шилдэг тоглогчоор Улаанбаатар салбарын З.Ганбаяр, эмэгтэй шилдэг тоглогчоор Зүүн-Өмнөд бүсийн салбарын Д.Ганчулуун, волейболын шилдэг эрэгтэй тоглогчоор Хангайн бүсийн салбарын Б.Амар, эмэгтэй шилдэг тоглогчоор Говийн бүсийн салбарын Б.Ундрам нар шалгарч, баг тамирчдыг манлайлав.

ШИНЭ УУЛЗАЛТЫН ӨРӨӨ АШИГЛАЛТАД ОРЛОО



зорилгоор уулзалтын өрөөг шинээр тохижуулж, ашиглалтад орууллаа.

Шинэ орчин нь ажилтнуудын түр амсхийж, эрч хүчээ нөхөн сэргээхээс гадна эерэг харилцааг бэхжүүлэх чухал орон зай болж байна. Тав тухтай суудал, эрүүл ахуйн шаардлага хангасан шийдэл, тайвшруулах өнгө дизайны зохицол нь албан уулзалтыг илүү чөлөөтэй, найрсаг уур амьсгалд хийх боломжийг бүрдүүлжээ.

Энэхүү өрөөг төв удирдлагын ажилтнуудын үйлдвэрчний эвлэлийн татвараар тохижуулсан бөгөөд зохион байгуулсан төв удирдлагын ҮЭХ, тусалж дэмжсэн компанийн удирдлагад талархал илэрхийлье.

Байгууллагын амжилтын үндэс нь ажилтны эрүүл мэнд, сэтгэл ханамж, ажлын бүтээмжтэй салшгүй холбоотой. Энэ зарчмыг эрхэмлэн, ажилтнууддаа тав тухтай, тайван орчин бүрдүүлэх



АЗ ЖАРГАЛЫН ӨРГӨӨ ҮҮДЭЭ НЭЭЛЭЭ




Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолд төр, хувийн байгууллага бүр хүүхдэд зориулсан өрөө эсвэл буланг тохижуулах үүргийг тусгасан байдаг.

Энэхүү үүргийн хүрээнд компанийн Үйлдвэрчний эвлэлийн хороо төв удирдлагын байранд хүүхдэд зориулсан өрөөг тохижуулж, 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр компанийн эцэг эхийн зөвлөлд хүлээлгэн өглөө.

Ингэснээр бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүд ажлынхаа тодорхой хугацаанд хүүхдээ тусгайлан тохижуулсан өрөөнд үлдээж, камерын хяналтын дор санаа зоволгүйгээр ажиллах боломжтой болжээ.

Энэ нь ажилтнуудын бүтээмжийг нэмэгдүүлж, байгууллагын гүйцэтгэл, үр дүнг сайжруулахын зэрэгцээ хүүхдүүдийг хичээл, цэцэрлэгээ тараад эцэг эхийнхээ ажил дээр ирэх үед тоглох, хөгжих, хичээлээ хийх нөхцөлөөр хангаж, хүүхдийн эрхийг хамгаалсан, болзошгүй эрсдэлээс сэргийлсэн орчин бүрдүүлж байгаа юм.





"ЦАХИЛГААН ТЕХНИКИЙН БАЙГУУЛАМЖИЙН УГСРАЛТЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ" БАТЛАХ ТУХАЙ

2025 оны 6 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар А/124

Улаанбаатар хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цахилгаан байгууламжийн угсралтын аюулгүй ажиллагааны дүрэм (ЭХД-1-12-04-2025)"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дүрмийг өөрийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг салбарын холбогдох үйлдвэр, компани, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг тус яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Насантогтох/, Салбарын хяналтын газар /П.Билгүүн-т, батлагдсан дүрмийг мэдээллийн санд байршуулах, нийтэд түгээх ажлыг хариуцан зохион байгуулахыг "Эрчим хүчний эдийн засгийн хурээгэн" ТӨААТҮГ /М.Түмэнжаргал-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний сайдын 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Цахилгаан байгууламжийн угсралтын аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Б.ЧОЙЖИЛСҮРЭН

ДАМЖУУЛАХЫН ЗАЛУУС ТББ

ДАМЖУУЛАХЫН ЗАЛУУС ТББ-ААС ЗОХИОН БАЙГУУЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ ТЭРГҮҮН БАЙРНЫ ЭЗЭД ТОДОРЛОО




Дамжуулахын залуусын мэдлэг боловсролыг чадваржуулах, байгууллагын соёлыг бий болгох чиглэлээр ажилтнуудын судалгааны ажлын дэмжих, шинэлэг санаа, иновацийг хөгжүүлэх, 90/10 хөтөлбөрийг оновчтой үр бүтээлтэй хэрэгжүүлэх зорилгоор нийт ажилтнуудын дунд эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг зарласан.

Уг уралдаанд нийт 17 эрдэм, шинжилгээний ажил ирснээс төв удирлагын Мэдээлэл технологийн хэлтсийн инженер Ш.Аюурзана, А.Алтан-Очир нарын "Монгол Улсын нэгдсэн сүлжээний давтамжийн тогтворжилтод Бөөрөлжүүт цахилгаан станцын үзүүлэх нөлөө ач холбогдол" сэдэвт илтгэл тэргүүн байранд шалгарсан байна.

ТӨВИЙН БҮСИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭНИЙ ХОНОГИЙН АЧААЛЛЫГ ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ АЛГОРИТМ АШИГЛАН ТААЦЛАХ СУДАЛГАА

Хиймэл оюун ухаанаар цахилгаан ачааллыг таацлах шинэ судалгаа Монгол Улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж, системийн найдвартай ажиллагааг хангах шаардлага улам бүр чухал болж байна. Энэ чиглэлээр ЦДҮС ТӨХК-ийн инженерүүд Ш.Аюурзана, А.Алтан-Очир нар хиймэл оюун ухааны алгоритм ашиглан Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний хоногийн ачааллыг таацлах судалгааг хийжээ.

Судалгаанд 2021–2025 оны СКАДА системийн ачааллын өгөгдөл болон цаг уурын мэдээллийг ашиглаж, Random-Forest, XGBoost, GradientBoost-

ing зэрэг машин сургалтын алгоритмуудыг харьцуулсан байна. Үр дүнгээс харахад эдгээр алгоритмууд уламжлалт статистик аргуудаас илүү өндөр нарийвчлалтай таамаг гаргаж, системийн ачааллыг цаг уурын нөхцөлтэй уялдуулан бодитой таацаж чаджээ.

Тухайлбал, цахилгаан хэрэглээ жил бүр дунджаар 10 орчим хувиар өсөж, хамгийн их ачаалалтай сар нь 1-р сар, хамгийн их ачаалалтай цаг нь оройн 19:00–20:00 цаг байв. Харин наадмын өдрүүдийн хэрэглээ ердийн зуны өдрүүдээс 45 хувиар бага гарсан нь онцлог аж. Судалгааны дүнгээр температур, чийгшил, салхины

хурд зэрэг цаг уурын хүчин зүйлс хамгийн их нөлөөтэй болохыг тогтоосон байна.

Энэхүү судалгааны практик ач холбогдол нь:

- Эрчим хүчний системийн горим төлөвлөлтийг оновчлох
- Нөөцийг үр ашигтай хуваарилах
- Сэргээгдэх эрчим хүчийг системд нэгтгэх боломжийг нэмэгдүүлэх


Инженерүүдийн дүгнэлтээр хиймэл оюун ухаанд суурилсан таацын арга нь диспетчерийн үйл ажиллагааг сайжруулж, системийн найдвартай ажиллагааг хангахад чухал хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна.

ЖЕНДЭР

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ХАРИЛЦАХДАА АНХААРАХ ЗҮЙЛ


ТҮЛХЭХГҮЙ БАЙХ

Машинд суухад болон хаалгаар орох үед нь тайван хандаж хүндэтгэх.



ТОХОЙНООС НЬ ТҮШ

Харааны бэрхшээлтэй хүний хөтөч, чиглүүлэгч хийж байгаа бол тохойноос нь барьж, нэг алхмын өмнө яваарай.



ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ХАРИЛЦАХДАА АНХААРАХ 3 ЗҮЙЛ

АСУУ

Ямар тусламж хэрэгтэй байгааг нь эхлээд асууж, шаардлагатай бол зам хөндлөн гарахад нь туслаарай. Албан байгууллага, автобусны буудлын хаяг асуувал зааж өгөөрэй.



ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР ЕВРОПЫН ХОЛБООНЫ ТӨСӨЛД ХАМРАГДЛАА



Төвийн бүсийн салбар нь Дархан-Уул аймгийн эмэгтэйчүүдийн холбооны гишүүн байгууллагын хувьд Европын Холбооны санхүүжилттэй "Хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийг чадавхижуулах, эрүүл, аюулгүй, эрх тэгш ажлын байрны орчинг бэхжүүлэх" төсөлд шалгарч, 18 байгууллагын хамт хөтөлбөрт хамрагдах болсон.

2026–2029 онд хэрэгжих уг төсөл нь Дархан-Уул аймагт хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, эрүүл аюулгүй, жендэрийн мэдрэмжтэй ажлын

байрны орчныг сайжруулахад чиглэх бөгөөд байгууллагын дотоод орчин, ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөлд бодит ахиц болов.

Төслийн нээлтийн үйл ажиллагаа 2026 оны 03-р сарын 06-нд болж, "Хөдөлмөр эрхлэлт ба Эмэгтэйчүүд" сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулагдав. Хэлэлцүүлэгт салбарын 11 ажилтан оролцож, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн тулгамдсан асуудал, шийдэл, боломжийн талаар санал бодлоо солилцсон байна.

САЛБАНУУДЫН МЭДЛЭГИЙН ЭЭЛЖИТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ

Шалгалтын үйл ажиллагааны талаар

Гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн дагуу 2026 оны 01–03 дугаар сарын хугацаанд 7 салбарын хэмжээнд мэдлэгийн ээлжит шалгалтыг зохион байгууллаа. Шалгалтыг салбаруудын шалгалтын комисс танхим, цахим, аман болон ур чадварын хосолсон хэлбэрээр зохион байгуулсан.

Шалгалтад хамрагдсан байдал

Улаанбаатар салбар 390, Төвийн бүс 120, Зүүн-Өмнөд бүсийн салбар 175, Говийн бүс 60, Баруун бүс 70, Хангайн бүс 80, Алтай-Улиастайн 40 ажилтан нийт, 935 ажилтан ээлжит мэдлэгийн шалгалтанд хамрагдсан байна. Шалгалтын нэгдсэн дүн Ээлжит шалгалтын үр дүн (ойролцоогоор)

- Хангалттай үнэлгээ: ~78% (730 ажилтан)
- Хангалтгүй үнэлгээ: ~22% (205 ажилтан)

Давтан шалгалтын дараах үр дүн

- Хангалттай болсон: ~95% (890+ ажилтан)
- Үлдсэн хангалтгүй: ~5% (4 ажилтан)

Давтан шалгалтад хангалтгүй дүн үзүүлсэн ажилтнуудад сургалт зохион байгуулж, 3 дахь шалгалтад хамруулж бүх ажилтнууд хангалттай дүн үзүүлсэн.

Цаашид салбаруудад авах арга хэмжээ

- Аюулгүй ажиллагааны дүрмийн (ААД) мэдлэгийг сайжруулах чиглэлээр
 - сар бүрийн давтан зааварчилгааны чанарыг сайжруулах
 - бодит осол, зөрчилд суурилсан кейс сургалт зохион байгуулах
- Шалгалтын хэлбэрийг боловсронгуй болгох Ээлжит шалгалтыг
 - тест + аман болон бичгээр + ур чадварын хосолсон хэлбэрээр зохион байгуулж байх
- Цахим шалгалтын системийг хөгжүүлэх,
 - тестийн санг нэмэгдүүлэх, шинэчлэх
 - ААД, ТАД болон хууль, дүрмийн асуултын жинг нэмэгдүүлэх
 - шалгалтыг богино хугацаанд, ил тод, чанартай зохион байгуулах боломжийг бүрдүүлэх.
- ХАБЭА-н ур чадварын үнэлгээг бүх салбарт нэвтрүүлэх, ажилтнууд ажлын байранд дахь аюулыг илрүүлж, эрсдэлийг үнэлж, түүнд хяналт тогтоож чаддаг арга барилыг бүрэн эзэмших чиглэлд сургалт болон шалгалтыг зохион байгуулж байх /Мэдлэгийн болон ХАБЭА-н ур чадварыг үнэлэх журмыг мөрдөх/
 - практик шалгалтыг бүх салбарт нэвтрүүлэх
 - ажлын байрны дадлага, кейс дээр суурилсан үнэлгээ хийх

- туршлагатай ажилтнаар дадлагажуулах тогтолцоог сайжруулах,
- Сургалтын үйл ажиллагааг сайжруулах Сургалтын инженерүүдийн:
 - мэдлэг, арга зүй, ур чадварыг дээшлүүлэх
 - салбар хооронд туршлага солилцох
 - сургалтыг нэгдсэн төлөвлөгөөг чанаржуулж, хэрэгжүүлэх,
 - Шалгалтын материалын чанарыг сайжруулах
 - шалгалтын тест, материалыг нэгдсэн байдлаар боловсруулах
 - комиссын даргаар хянуулж баталгаажуулах, мэдлэгийн шалгалтын комиссыг шалгалтын материал бэлдэх үйл явцад оролцуулах
 - бодит ажлын нөхцөлд нийцсэн асуултыг түлхүү оруулах,
 - Хяналт, үнэлгээний тогтолцоог сайжруулах
 - салбаруудын шалгалтын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих
 - шалгалтын үр дүнг дүн шинжилгээ хийж тайлагнах
 - гүйцэтгэлд суурилсан үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх. /дүрмийн мэдлэгийг дээшлүүлэхээс гадна түүнийг ажил дээр зөв мөрдөж ажиллах боломжоор хангах/

АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАСНЫ ШИНЭ СТАНДАРТ БАТЛАГДЛАА



Компанийн үйл ажиллагааны аюулгүй байдал, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, нэгдсэн дүр төрхийг бүрдүүлэх зорилгоор ажлын тусгай хувцасны шинэ стандартыг 2026 онд батлан мөрдүүлж эхэллээ.

Шинэ стандарт нь ажлын байрны онцлог, эрсдэлийн түвшинд нийцсэн байх зарчмыг баримталж, дараах үндсэн шаардлагуудыг тусгасан болно.

Ажлын тусгай хувцсаар хангагдах ажилтны ангилал

Ажлын байр, хөдөлмөрийн нөхцөлөөс хамааруулж ажлын тусгай хувцсаар хангагдах ажилтнуудыг гурван хэсэгт хуваана.

- Ажлын тусгай хувцсаар хангах I хэсэг: Компанийн удирдлага, хэлтэс,

салбар, албаны дарга нар, цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжтэй харьцаж ажилладаггүй бусад ажилтнуудад зориулсан хүрэм, хантааз эсвэл цамц байна.

- Ажлын тусгай хувцас хангах II хэсэг: Компанийн ИТА-ууд, дэд станц, шугам тоноглолын засвар үйлчилгээ, реле хамгаалалт, хоёрдогч хэлхээ, хэмжүүр, тоолуур, туршилт, холбооны инженер, засварын монтёр, автын засварчин, механик, өргөх тээврийн хэрэгслийн жолооч, аж ахуй ажил гүйцэтгэгч мужаан, гагнуурчин, слесарь, харуул, ачигч, бараа материалын нярав нар өмсөх хүрэм, өмд бүхий хослол байна. Мөн хантааз, цамцыг журмын дагуу олгоно.

- Ажлын тусгай хувцас хангах III хэсэг: Дэд станц, ил хуваарилах байгууламжид ажилладаг шуурхай ажиллагааны ээлжийн инженер, техникч, монтёр нар өмсөх хүрэм, өмдний хослол байна. Цамцыг журмын дагуу олгоно.

ТЕХНИКИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

ТӨВИЙН БҮСИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙН ӨВЛИЙН ГОРИМД АЧААЛАЛ ОРГИЛДОО ХҮРЭВ

2025–2026 оны өвлийн горим ажиллагааны явцад ТБНС-ийн ачаалал 1 дүгээр сарын 19-нд оргилдоо хүрч, 1803 МВт болсон бол шөнийн бага ачааллын үед 1420 МВт-д хүрсэн байна.

Салбаруудын хэмжээнд УБС – 1130 МВт,

ТБС – 106.9 МВт,

ХБС – 313.5 МВт,

ЗӨБС – 150.9 МВт,

ГБС – 80.5 МВт,

АУС – 25.8 МВт,

ББС – 59.1 МВт ачаалал авч ажиллав.

2025-2026 оны өвлийн горим ажиллагаанд 220/110-кВ-ын ИХБ-4, 220/110/35 кВ-ын Улаанбаатар, 220/110/35 кВ-ын Сонгино дэд станцуудын автотрансформаторын ачаалал тулж, нэг автотрансформатороор ажиллах боломжгүй болсон бөгөөд дэд станцуудын хооронд ачааллыг шилжүүлж хэрэглэгчдийг ЦЭХ-ээр таслахгүй байх нөхцөл боломжгүй болоод байна.

Мөн 220/110/35-ын Багануур 110/10/6 кВ-ын Өмнөд 110/35/10 кВ-ын Дорнод-2 110/35/10 кВ-ын Туул 110/10 кВ-ын Улаанхуаран 110/35/10 кВ-ын Сэлбэ 110/35/10 кВ-ын Цэцэрлэг 10/35/10 кВ-ын Арвайхээр

110/35/6 кВ-ын Мөрөн дэд станцуудын ачаалал 80 хувиас дээш ачаалагдаж өвлийн оргил ачааллын цагууд болон гадна агаарын хүйтрэлттэй холбоотой 100 хувь болон түүнээс дээш ачаалагдав.

220/110/35кВ-ын Эрдэнэт дэд станцаас гарсан Булган-А, Б болон Хархорин-А, Б хэт урт шугамуудын ачаалал жил болгон нэмэгдсэнээр шугамын төгсгөлд 110/35/6 кВ-ын Баянхонгор дэд станцын хүчдэл 91 кВ хүртэл буурсан.

Хангайн бүсийн салбарын хэмжээнд 110/35/10 кВ-ын Хархорин дэд станцад 15МВар, 110/35/10 кВ-ын Баянхонгор дэд станцад 2*5 МВар+3МВар, 110/35/10

кВ-ын Баянтээг дэд станц дээр 3 МВар компенсалах хүчдэл өргөх төхөөрөмжүүд нэмж залгаж байгаа боловч ачааллын өсөлтийн хурд, шугамын уртын дагуу эх үүсвэр байхгүйгээс хүчдэлийн уналт гарсаар байна.

Компанийн хэмжээнд хоёр трансформатортой дэд станцуудаас 33 дэд станц нэг трансформаторын горимд ажиллах боломжгүй ачаалалтай болов.

2025-2026 оны өвлийн горимд компанийн үйлчлэх хүрээ нэмэгдэж Баруун бүсийн салбарын 110 кВ-ын 7 дэд станц, Алтай-Улиастайн салбарын 110 кВ-ын 5 дэд станц /110 кВ-ын пункт ороод/ нэмэгдсэн. Эдгээр салбаруудын үйлчлэх хүрээнд хамрагдаж байгаа сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр/нар, салхи, батарей нарны хослол, усан цахилгаан станцууд гэх мэт/ горим ажиллагааг судлах шаардлагатай.

Цаашид 2026-2027 оны өвлийн их ачааллын горим ажиллагаанд дээрх хэт ачаалагдаж байгаа дэд станцуудын ачааллыг хөнгөлөх, өргөтгөл шинэчлэлийн ажлууд төлөвлөж, БНХАУ-аас өвлийн оргил ачаалал зарим хэрэглэгчийг ЦЭХ-ээр хангахтай холбоотойгоор горим ажиллагаанд хүндрэл үүсэж болзошгүй учир тооцоо судалгааг нарийвчилж хийх, ЭХС-ийн тогтвортой, найдвартай, тасралтгүй, ажиллагааг хангаж ажиллаж байна.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2026 оны нэгдүгээр улиралд Эрчим хүчний яамны техникийн нөхцөлийн цахим системд 55 хүсэлт ирүүлснээс 15 дэмжигдэж, 33-н судалгааны шатанд, 7 нөхцөл олгох боломжгүй хариу өгч ажилласан. Сэргээгдэх эрчим хүчний 4 эх үүсвэрийн 180 МВт, батарей хуримтлуурын 1 эх үүсвэр 50 МВт-ын эх үүсвэрүүд барих техникийн нөхцөлүүд Эрчим хүчний яамны техникийн нөхцөл олгох ажлын хэсгээр дэмжигдээд байна.

Д/д	Холболтын цэг	Суурилагдсан чадал	Байрлал
1	110/35 кВ-ын Баянхонгор дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламж	20 МВт, 60 МВт*цаг багтаамжтай батарей хуримтлуурын станц	Баянхонгор аймаг, Өлзийт сум
2	220/110/35 кВ-ын Оюутолгой дэд станцын 220 кВ-ын ил хуваарилах байгууламж	102 МВт салхин станц, 163 МВт*цаг багтаамжтай батарей хуримтлуурын станц	Өмнөговь аймаг, Ханбогд сум
3	110/35/10 кВ-ын Бараат дэд станцын 35 кВ-ын ил хуваарилах байгууламж	9 МВт-ын суурилагдсан чадалтай нарны цахилгаан станц	Төв аймаг, Сэргэлэн сум
4	220/110/35 кВ-ын Чойр дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламж	50 МВт-ын суурилагдсан чадалтай нарны цахилгаан станц	Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум
5	220/110/35 кВ-ын Багануур дэд станцын 220 кВ-ын ил хуваарилах байгууламж	50 МВт-ын суурилагдсан чадалтай батарей хуримтлуурын цахилгаан станц	Багануур дүүрэг

Эрчим хүчний салбарын холбогдох дүрэм, стандартын шаардлагын дагуу компанийн хэмжээнд зургаан нөхцөл баталгаажсан байна.

Түгээх тусгай зөвшөөрөл бүхий компаниудад ачаалал хөнгөлөх, авто зам цахилгаан дамжуулах агаарын шугамтай огтлолцож буй хэсэгт техникийн арга хэмжээ авах шаардлагыг хангаж ажиллав.

Тухайлбал, “Цахилгаан байгууламжийн дүрэм” БД43-101-03-ын “Агаарын шугам авто замтай огтлолцох, ойртох” бүлгийн 2.5.98–2.5.101, мөн Монгол Улсад мөрдөгдөж буй MNS 65-22:2015 стандартын 9.7.2–9.7.3 заалтыг үндэслэн авто замын зорчих хэсэг болон ЦДАШ-ын дамжуулагч хоорондын зайг хангах техникийн нөхцөлүүдийг баталгаажуулсан байна.

КОМПАНИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ-ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР 16 АСУУДАЛ ХЭЛЭЛЦЭЖ ШИЙДВЭРЛЭВ



Компанийн 2026 оны ҮТЗ-ийн 1-р улирлын хурал 03 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулагдав. Энэ удаагийн хурлаар компанийн ИЗА, ТЗБАХ, УЗА, ХО-ын ажил эхэлж байгаатай холбоотой ажлын графикуудыг хэлэлцэж, хэлтсийн дарга, салбарын ерөнхий инженерүүдээс тулгамдаж байгаа асуудлаар санал, хүсэлтийг сонсож хэлэлцэн засварын ажлуудыг үр дүнтэй зохион байгуулах талаар үүрэг даалгавар өгөв. Компанийн хэмжээнд техник зохион байгуулалтын зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай нийт 16 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ШИНЭ ТҮВШИНД ОЧИЖ, 500 КВ-ЫН ЦДАШ, 550/220/110/35 КВ-ЫН ДЭД СТАНЦ БАРИГДАНА

Монгол Улсын хүн амын өсөлт, хотжилт эрчимжихийн хэрээр цахилгаан эрчим хүчний эрэлт тогтмол нэмэгдэж байна. Судалгаагаар 2050 он гэхэд хүн ам 5 саяд хүрэх төлөвтэй бөгөөд 2032 он гэхэд Улаанбаатар хот, МЕГА төслүүд болон дагуул хотуудын нийт хэрэглээ 4,448 МВт-д хүрэхээр байна.

Энэ өсөлтийг дагаад эрчим хүчний найдвартай, тасралтгүй хангамжийг бүрдүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байгаа тул өндөр чадлын дамжуулах дэд бүтцийг бий болгох зайлшгүй хэрэгцээ үүсчээ. Үүний хүрээнд шинэ эх үүсвэрүүдийг системд үр ашигтай холбож, дамжуулах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 500 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам шинээр барихаар төлөвлөж байна.

Нийслэлийн Багахангай дүүрэгт байрлах Нялга-Чойрын нүүрсний сав газарт Бөөрөлжүүтийн 600 МВт, Баянгийн 660 МВт, "Касэн Пауэр Грийн Энержи"-ийн 300 МВт чадалтай цахилгаан станцуудын бүтээн байгуулалт эхэлсэн бөгөөд эдгээр эх үүсвэрүүдийг холбох 2 хэлхээт, 216 км урт ЦДАШ-аар нийт 2000 МВт цахилгаан эрчим хүч дамжуулах боломжтой гэж тооцоолжээ.

Эдийн засгийн хүчдэлийн эмпирик томъёогоор тооцоход 460 кВ гарсан бөгөөд ахиулан тооцдог учраас 500 кВ-ын шугам хамгийн тохиромжтой шийдэл болох нь батлагдсан байна.

ХҮРЭХ ҮР ДҮН:

1. Эрчим хүчний системийн дамжуулах чадвар өснө 500 кВ түвшин нэвтрүүлснээр өнөөгийн 220 кВ шугамуудын хүчин чадлын хязгаарлалтыг бууруулж, 2000МВт хүртэл чадал дамжуулах боломж бүрдэнэ.

2. Сүлжээний ачааллын тэнцвэржилт, тогтвортой байдал нэмэгдэнэ УБ, Сонгино, Сөгнөгөр зэрэг дэд станцуудын АТ-уудын ачаалал 10–15%-иар буурна. 110 кВ тойргийн өндөр ачаалалтай шугамууд 10% орчим буурах нөхцөл бүрдэнэ.

3. Шинэ эх үүсвэрүүдийг системд аюулгүй холбох боломжтой бай Багахангай, Баянгийн, "Касэн Пауэр Грийн Энержи"-ийн, ИХБ-5 зэрэг шинээр баригдаж буй эх үүсвэрүүдийг дамжуулах хүчин чадлын ТБНС-д холбоно.


4. Хот байгуулалт ба МЕГА төслүүдийн эрчим хүчний хангамж сайжирна. 500 кВ сүлжээ байгуулагдсанаар: УБ метро, Трамвай, Дата төв, Эмээлт Эко парк, Хүннү хот/дагуул хотууд зэрэг том хүчин чадлын хэрэглээтэй дэд бүтцүүдийг ЦЭХ-

ээр найдвартай тасралтгүй хангах үндэс бүрдэнэ.

5. Дамжуулалтын алдагдал буурна (эрчим хүчний үр ашиг сайжирна), гүйдэл 220 кВ-аас 4 дахин бага тул шугамын актив алдагдал эрс багасна. ЦДАШ-ын дамжуулалтын үр ашиг мэдэгдэхүйц өснө.

6. Олон улсын туршлагад тулгуурласан шугамын өндөр, хамгаалалтын зурвас, EMF-ийн хяналт, Шувуу хамгаалах, газардуулгын систем, гал дэмждэггүй ACSR утас ашиглана. Статистикийн дагуу 500 кВ

- Төлөвлөж буй цахилгаан эх үүсвүүр (3 багц)
- Төлөвлөж буй 500 кВ-ын дэд станц (3 багц)
- Төлөвлөж буй 220 кВ-ын дэд станц (5+3 багц)
- Төлөвлөж буй 500 кВ-ын ЦДАШ (хагас тойрог систем)
- Төлөвлөж буй 220 кВ-ын ЦДАШ
- 220 кВ-ын ЦДАШ



Шугамын урт [км]	81	135
Дамжуулах чадал [МВт]	2000	
Чадал коэффициент	0.96	0.96
Хэлхээ	2	
Хүчдэл [кВ]	460	461.7

шугам нь 220 кВ-аас гэмтлийн түвшин бага гэдгийг тоон мэдээллээр баталсан.

7. Хотын эрчим хүчний хомсдолын эрсдэлийг бууруулж, үйлдвэрлэл, экспортыг дэмжинэ. Том чадлын эх үүсвэрүүдийг системд найдвартай холбох суурь систем бүрдэнэ.

8. Улс орны хэмжээнд хөгжлийн стратегийг дэмжих шинэ түвшний дэд бүтэц болно.

ШУУРХАЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭС

ЭХНИЙ УЛИРЛЫН ҮР ДҮНТЭЙ АЖЛУУД

2026 оны эхний дөрвөн сарын байдлаар компанийн хэмжээнд 220/110 кВ-ын тоноглолуудад төлөвлөгөөт засвар үйлчилгээ болон бүтээн байгуулалтын ажлууд амжилттай үргэлжилж байна. Энэ хугацаанд ИЗА, УЗА, ТЗБАХ, өргөтгөл шинэчлэлт болон төслийн ажлуудын хүрээнд, мөн гарсан гэмтэл саатлыг шуурхай устгах зорилгоор нийт 175 удаагийн ажлын байр бэлтгэх сэлгэн залгалтыг техникийн болон аюулгүй ажиллагааны дутагдалгүй хийж гүйцэтгэлээ.

- 2022-2023 оны өвлийн ачааллын үеэр гэмтэл авсан №68 дугаар тулгуур болон алгасалт ихтэй №126 дугаар тулгуурыг шинэчлэх төслийг амжилттай хэрэгжүүлэв.

Үйлдвэр техникийн зөвлөлийн шийдвэрийн дагуу эдгээр

тулгууруудыг У-220/2Т+9 маркийн анкер тулгуураар солих ажил хийгдэж 03 дугаар сарын 16-ны өдрийн 06:00 цагаас 03 дугаар сарын 30-ны 18:22 цаг хүртэлх хугацаанд ажлын байр бэлтгэх сэлгэн залгалтыг шуурхай гүйцэтгэж, угсралт, шинэчлэлтийн ажлыг богино хугацаанд, төлөвлөгөөт хуваарийн дагуу амжилттай зохион байгууллаа.

- Мөн хугацаанд KFW төслийн хүрээнд Хэнтий (ХБС), Төв (ТБС), Замын-Үүд (ЗӨБС), Улаанбаатар (УБС) зэрэг нийт 9 дэд станцад таслуур, гүйдлийн трансформатор (ГТ) болон реле хамгаалалт, автоматикийн (РХА) иж бүрэн шинэчлэлийн ажлуудыг амжилттай хэрэгжүүлж байна. Уг ажлын хүрээнд манай баг бүрэлдэхүүн:

Техникийн оновчтой схемийн шийдлүүдийг боловсруулж;

Аюулгүй ажиллагааг ханган ажлын байр бэлтгэх сэлгэн залгалтуудыг гүйцэтгэж;

Шинээр суурилуулсан тоноглолуудыг хүчдэл дор амжилттай залгаж, хэвийн схем горимд шилжүүлэн эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.

- ИЗА, УЗА, ТЗБАХ, өргөтгөл шинэчлэлийн ажлыг таслалтын нэгдсэн графикт оруулж, нэг удаагийн таслалтаар олон төрлийн ажлыг зэрэг гүйцэтгэх зарчмыг удирдлагуудаар батлуулан хэрэгжүүлж байна.

- 3-р сард нойтон цас, хүчтэй салхи шуурганы үеэр урьдчилан сэргийлэх телефонограмм хүргүүлж, салбар дэд станцуудад ээлжит бус үзлэг хийснээр гарч болзошгүй гэмтэл зөрчлийг цаг алдалгүй илрүүлж, арга хэмжээ авлаа.

Компанийн I улирлын аваар эсэргүүцэх дасгалыг "Хангайн бүсийн салбарт 110/35/10 кВ-ын Сансар, Хишиг-Өндөр дэд станцын ачааллыг 110 кВ-н Хархорин-А АШ-д шилжүүлэх сэлгэн

залгалтын үед 110/35/10 кВ-ын Хишиг-Өндөр дэд станц 110 кВ-н Хархорин-Б АШ-н шугам талын колонк хугарч, 110 кВ-н хархорин-А,Б АШ-д богино залгаа үүсэх үед авах арга хэмжээ" сэдвээр амжилттай зохион байгуулж, АШҮА-ны хүмүүст сургалт зохион байгуулсан.



Аваар эсэргүүцэх дасгалын үеийн зураг



03.204-р АШ-н тулгуур №68,126-г солих ажлын явцын зураг

ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД СТАНЦУУДЫН ШИНЭЧЛЭЛ БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН АЖЛУУД ЭРЧИМТЭЙ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

Германы Сэргээн босголт, зээлийн банкны (KfW) хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Төвийн бүсийн дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх" төслийн хүрээнд томоохон шинэчлэлийн ажлууд хийгдлээ. Тухайлбал,

Хялганат, Хархорин болон Булган дэд станцуудад 110 кВ болон 35 кВ-ын хүчдэлийн таслуур, хуурай салгуур, реле хамгаалалт, автоматийн (РХА) тоноглолуудыг иж бүрэн шинэчлэн суурилуулаад байна.

Төслийн дараагийн шатны бэлтгэл ажил хангагдсан бөгөөд 2026 оны 3-7 дугаар сард Эрдэнэт, Арвайхээр, Цэцэрлэг, Сансар,

Хишиг-Өндөр дэд станцуудад шинэчлэлийн ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Мөн Үйлдвэрлэл технологийн паркийн гадна цахилгаан хангамжийг шийдвэрлэх ажлууд амжилттай үргэлжлэн "Оюут" 220/110/35 кВ-ын дэд станцын барилга угсралтын ажил 70 хувьтай, 220 кВ-ын ЦДАШ болон Эрдэнэт дэд станцын өргөтгөлийн ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна. Эдгээр ажлыг 2026 оны 10-11 дүгээр сард бүрэн дуусгаж, улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

ТЗБАХ-НЫ 2025 ОНЫ АЖЛЫН ХҮРЭЭНД

Эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах зорилгоор ТЗБАХ-ны 2025 оны төлөвлөгөөний дагуу хэд хэдэн дэд станцад өргөтгөл, шинэчлэлтийн ажил хийгдлээ.

- 220/110/35/6 кВ-ын Эрдэнэт дэд станцад 35 кВ-ын 9 ком хуурай салгуур, 2 ком таслуурыг ГТ-н хамт шинээр сольж суурилууллаа.

- 110/35/10 кВ-ын Хишиг-Өндөр дэд станцын 10 кВ-ын КРУН-г бүрэн шинэчилсэн.

-110/35/10 кВ-ын Булган дэд станцын ШДХ-ыг шинээр сольж, өргөтгөсөн.

-110/35/10 кВ-ын Хархорин, Цэцэрлэг дэд станцуудын ИХБ-д хяналтын камер суурилуулж, аюулгүй ажиллагааг сайжруулсан.

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМЫН ТАЛААР

Хангайн бүсийн салбар нь 2025 онд хэд хэдэн өндөр хүчдэлийн ЦДАШ-д засвар, шинэчлэлтийн ажил хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан. Тухайлбал,

- 110 кВ-ын Булган-А, Б ЦДАШ Т№105-154 хооронд 1 ширхэг анкер тулгуур шинээр босгож хүчитгэл хийснээр үүсэж болзошгүй хохирлын эрсдэлийг бууруулсан.



АЛТАЙ-УЛАЙСТАЙН САЛБАР

АЛТАЙ-УЛИАСТАЙН САЛБАР БАЙГУУЛАГДАВ



Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 30-р тогтоол, Эрчим хүчний сайдын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/259-р тушаал, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн ТУЗ-ын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 24-р тогтоолыг үндэслэн "ЦДҮС" ТӨХК-ийн Алтай-Улиастайн салбар 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдөр албан ёсоор үүсгэн байгуулагдлаа.

Одоогоор 56 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж буй тус салбар нь 2025 оны 12 дугаар сараас эхлэн:

110 кВ-ын 421 км урт ЦДАШ, 110/35/10 кВ-ын Тэлмэн дэд станц, 110/35/10 кВ-ын Улиастай дэд станц, 110/10 кВ-ын Цагаанчулуут дэд станц, 110/35/10 кВ-ын Говь-Алтай дэд станц болон салбарлалтын нэг пунктын ашиглалтыг хариуцан ажиллаж байна.

Ингэснээр Завхан, Говь-Алтай аймгийн 44 сум, сууринг цахилгаан эрчим хүчээр хангах чухал үүргийг гүйцэтгэж байгаа юм. Салбарын онцлог нь том, жижиг олон эх үүсвэрүүдтэй холбогдон горимын тохируулга хийж ажилладаг.

ОНЦЛОХ ТОМООХОН АЖЛУУД

- ТӨБЭГ-ын 389-р тогтоолын дагуу АУЭХС ТӨХК-өөс хөрөнгө хүлээлцэж, хөрөнгийг бүртгэлжүүлсэн.
- Шинээр байгуулагдсан салбарын оффисын ажиллагсдын ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр оффисын байрны засвар тохижилт, компьютер техник хэрэгслээр хангах асуудлыг шийдвэрлэн ажилласан.
- Салбарын хэмжээнд SCADA системийг үүсгэхээр энэ жилдээ хоёр дэд станцыг дотоод сүлжээнд холбохоор төлөвлөн ажиллаж байна.
- 110кВ Тайшир салбарлалтын пунктыг камерын системээр хянах боломж бололцоог бий болгохоор ажиллаж байна.
- 110кВ Улиастай-Тайшир 7 агаарын шугамын тулгуур тэгшлэсэн.
- 110кВ ЦДАШ-н тусгаарлагч 1500 элемент сольсон.
- 110кВ АШ-ын тулгууруудад үерийн эрсдэлтэй 8 хэсэгт намгийн хамгаалалт, татуурга хийсэн.
- 110кВ-н АШ-ын 12 ширхэг анкер тулгуурыг зэврэлтээс хамгаалж будав.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн MNS 4969:2000 стандарт, болон цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд цаашид ашиглалтын үед хүн хүч, тоног төхөөрөмж, машин механизмын аюулгүй ажиллагааг сайтар хангаж осол аюулгүй ажиллахаар зорьж байна.

АЛТАЙ-УЛИАСТАЙН САЛБАРТАЙ ХОЛБОГДОЖ БАЙГАА ЭХ ҮҮСВЭРҮҮД



ТӨЛӨВЛӨГӨӨТ ЗАСВАРЫН АЖИЛ АМЖИЛТТАЙ ХИЙГДЛЭЭ



2025 онд батлагдсан төлөвлөгөөт засварын ажил ТЗБАХ №02-ын хүрээнд цахилгаан эрчим хүч дамжуулах шугамын найдвартай ажиллагааг хангах зорилгоор томоохон засварын ажлыг гүйцэтгэлээ.

2026 оны 03-р сарын 10–11-ний өдрүүдэд 225-р АШ-ын Т№646, 553 овор барихгүй цэг буюу анкер тулгуурын алгасалт ихтэй хэсгүүдэд СК-26 маркийн завсрын тулгуурыг буулгаж, шинэ анкер тулгуур босгох ажлыг зохион байгуулсан байна. Энэхүү ажлыг засварын инженер Б.Лхагвасүрэнгээр ахлуулсан 20 хүнтэй бригад, 7 машин механизмтайгаар гүйцэтгэсэн.



СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ, “ЭЗЭН БАЙЯ” САРЫН АЯН ЭХЭЛЛЭЭ

Инженер техникийн ажилтнуудын судалгааны ур чадварыг хөгжүүлэх, шинжлэх ухаанч сэтгэлгээг төлөвшүүлэх, тулгамдсан асуудлыг онол практикийн үүднээс судлан дүгнэх, шийдэл боловсруулах зорилгоор салбарын даргын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/03 дугаар тушаалаар “Судалгаа шинжилгээний ажил зохион байгуулах тухай” тушаал батлагдан хэрэгжиж эхэллээ. Энэхүү ажил нь Салбарын нийт 57 инженер техникийн ажилтнуудыг 15 багт хуваарилан сонгогдсон сэдвийн хүрээнд болзолт уралдаан 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал зохион байгуулахаар төлөвлөсөн.

Мөн ажилтан бүр албан тушаалын хүрээнд хариуцсан үүрэгтээ эзэн болж, хувийн сахилга баттай, үүрэг хариуцлагаа ухамсарлан ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж, бүтээмжтэй ажиллахад чиглэж салбарын даргын баталсан удирдамжийн дагуу “Эзэн байя” сарын аяныг 2026 оны 02 дугаар сарын 01-нээс 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хэрэгжүүлэх байна.

Аяны хүрээнд алба бүр нэг сарын хугацаанд 4 үндсэн чиглэлийг зорилго болгон ажил зохион байгуулах юм.

БАРУУН БҮСИЙН САЛБАР

БАРУУН БҮСИЙН САЛБАР БАЙГУУЛАГДАН ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЭХЛҮҮЛЛЭЭ

БАРУУН БҮСИЙН САЛБАР
УВС, ХОВД, БАЯН-ӨЛГИЙ



110 кВ-ын 764.1 км шугам 131,9 МВА

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 24 тоот тогтоолоор Баруун бүсийн салбар албан ёсоор байгуулагдав.

Өнөөдрийн байдлаар тус салбар нь 6 алба, 2 хэсэг, нийт 114 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Салбар нь ОХУ-аас импортын эрчим хүчийг хүлээн авахын зэрэгцээ Дөргөний УЦС, “Ховд Нар” НЦС гэсэн гурван эх үүсвэрээс эрчим хүч дамжуулан авч, 110 кВ-ын 764.1 км ЦДАШ, 110 кВ-ын 7 дэд станцаар дамжуулан баруун бүс нутгийн хэрэглэгчдийг хангаж байна.

Баруун бүсийн салбар нь баруун бүсийн 3 аймаг, 52 сум, 40 гаруй багийн төв, суурин газар, айл өрх, аж ахуйн нэгжүүдийг цахилгаан эрчим хүчээр ханган ажиллаж байгаа нь салбарын үйл ажиллагааны гол чиглэл болж байна.

ОХУ



ОНЦЛОХ ТОМООХОН АЖЛУУД

- 110/35/10 кВ-ын Өмнөговь дэд станцын 0.4 кВ-ын хуваарилах байгууламж шинэчлэх;
- 110 кВ-ын Өмнөговь-Мянгад АШ-д тулгуур тэгшлэх, татуурга хийх;
- 110 кВ ЦДАШ-н тусгаарлагч элемент солих;
- Улаангом, Өмнөговь, Мянгад д/с-ын реле хамгаалалтын их засвар хийх;
- Төв оффист салбарын диспетчерийн өрөөг шинээр гаргах, засварлах;
- 110 кВ-ын Тосон таслуурыг элегаз таслуураар солих;
- 110 кВ-ын хуурай салгуур солих;
- 35 кВ-ын хуурай салгуур сольж шинэчлэх;
- 35 кВ-ын ТТ-ыг вакуум таслуур сольж шинэчлэх;
- 110 кВ-ын С-457, 458-р АШ-н схемийн өөрчлөлт, 110/35/10 кВ-ын Сагил дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл хийлгэх;
- Өндөр хүчдэлийн 1 фазын туршилтын трансформатор, газардуулгын эсэргүүцэл хэмжигч худалдан авах;

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ГЭМТЛИЙГ ХУРДАН ШУУРХАЙ УСТГАВ



Баруун бүсийн салбарын Засварын албаны инженер техникийн ажилтнууд Их нууруудын хотгорын эрс тэрс уур амьсгалтай бүс нутагт байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас үүссэн гэмтлийг шуурхай арилгасан.

2026 оны 01-р сарын 18-ны өдөр Увс аймгийн Тариалан сумын “Хүйтэний ам” хэмээх газарт -42 градус хүртэл хүйтэрсний улмаас 110 кВ-ын Улаангом–Өмнөговь 2 хэлхээ ЦДАШ-д гэмтэл гарсан байна. Тодруулбал, 92-р транспозец анкер тулгуураас 94-р завсрын тулгуур хооронд А фазын дамжуулагч утас хүчний үйлчлэлээр чангаралтад орж, 93-р завсрын тулгуурын А фазын дамжуулагч утас нь лочикийн хэсэгт тасарч газарт унан нэг фазын газардлага үүсэж тасарсан гэмтлийг устгасан.



ТӨВИЙН БҮСИЙН САЛБАРЫН 60 ЖИЛИЙН ОЙГОО ТЭМДЭГЛЭЛЭЭ



Монгол Улсад 110 кВ-ын Дархан-Шарын голын ЦДАШ-ыг 1963 оны 3-р сард, Дархан-Сүхбаатарын шугамыг 1965 онд ашиглалтад оруулснаар Дархан-Сэлэнгийн районд цахилгаан дамжуулах сүлжээний эхний цогцолбор бий болсон түүхтэй.

1965 оны 4-р сарын 1-нд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор “Дархан-Сэлэнгийн Цахилгаан Шугам Сүлжээний Газар” байгуулагдаж, улмаар 1976 онд 220/110/35 кВ-ын Дархан дэд станц ашиглалтад орсноор Монголын эрчим хүчний систем ЗХУ-ын Дорнод Сибирийн системтэй зэрэгцээ ажиллагаанд холбогдсон нь улсын хөгжилд томоохон өөрчлөлт авчирсан юм.

2001 онд бүтцийн өөрчлөлтөөр хувьцаат компанийн хэлбэрт шилжиж, 2012 оноос “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн “Төвийн бүсийн салбар” нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Өнөөдөр тус салбар нь 220/110 кВ-ын түвшний 18 дэд станцын засвар, үйлчилгээг хариуцан, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг болон Төв аймгийн хойд чиглэлийн 7 сумыг цахилгаанаар найдвартай хангаж, улсын эдийн засгийн гол үйлдвэрүүдийг эрчим хүчээр тасралтгүй хангаж байна.

Салбарын суурилагдсан хүчин чадал 1976 онд 327 МВА байсан бол 2025 оны байдлаар 482.8 МВА болж, 32.3 хувиар өсжээ.

Салбарынхаа тоног төхөөрөмжийг шинэчилж, дэлхийн стандартад нийцсэн техник технологийг нэвтрүүлж компанийн алсын хараа болсон “УХААЛАГ СҮЛЖЭЭ” зорилтыг салбартаа анх нэвтрүүлсэн салбар. Сүүлийн 5 жилийн хугацаанд тоолуурын нэгдсэн систем, СКАДА хяналтын системийг нэвтрүүлж 18 дэд станцын горим ажиллагаа, цахилгаан параметрууд, тоноглолын төлөвүүдийг цахимаар хянах ажлыг хэрэгжүүлсэн ба 4 дэд станцыг алсын удирдлагын системийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа мэргэжлийн өндөр ур чадвартай инженерүүдтэй.

208 ажилтантай хамт олон нь өнгөрсөн 60 жилд олон гавьяатнууд төрүүлж, салбарынхаа түүхэн замналыг бүтээлч хөдөлмөрөөрөө бичиж ирсэн. Ойн хүрээнд төв оффис болон дэд станцуудын тохижилт, сургалтын төв, эрдэм шинжилгээний хурал, мод тарих хөдөлгөөн зэрэг 60 төрлийн ажлыг зохион байгуулсан бөгөөд 2025 оны 12-р сарын 16-нд гурван үеийн ажилтнуудын нэгдсэн уулзалт өдөрлөгөөр ойгоо тэмдэглэн өнгөрүүлээ.

ДАРХАН ХОТЫН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙГ НАЙДВАРТАЙ БОЛГОХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ЭРЧИМЖИЖ БАЙНА

1. Дархан – Мангирт 110 кВ-ын 1 хэлхээ ЦДАШ - 11,5 км	- 90%
2. Мангирт – Ноёнхонгор 110 кВ-ын 1 хэлхээ ЦДАШ - 12,1 км	- 80%
3. Тосгон – Ноёнхонгор 110 кВ-ын 2 хэлхээ агаарын шугам 8,12 км	- 0%
4. 110/35/10 кВ-ын “МАНГИРТ” дэд станц – 2*16 МВА хүчин чадалтай	- 70%
5. 110/35/10 кВ-ын “НОЁНХОНГОР” дэд станц – 2*16 МВА хүчин чадалтай	- 0%
6. 220/110/35 кВ-ын “ДАРХАН” дэд станц – 110 кВ-ын СШ ний өргөтгөл	- 50%

Дархан-Уул аймгийн газрын албатай хамтран хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн цаашид өргөжин тэлэх дэд бүтцийн судалгаа хийгдэж, 110/35/10 кВ-ын “Ноён хонгор” болон “Мангирт” дэд станцыг шинээр барих шийдвэр гарсан. Газрын зөвшөөрөл авах, кадастрын зураглалд тусгах ажил шат дараатай хийгдэж байгаа бөгөөд хоёр дэд станцыг холбох 15 км урт 110 кВ-ын агаарын шугамын трассын зураглал ч боловсруулагджээ.

Дархан-Уул аймгийн өсөн нэмэгдэж буй цахилгаан хэрэглээг хангах, найдвартай ажиллагааг бүрдүүлэх зорилгоор улсын болон орон нутгийн төсөвт тусган үе шаттай ажлууд хэрэгжиж байна.

“Дархан тойрог схем”-ийн дагуу 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 кВ-ын дэд станцын барилга угсралт, схемийн өөрчлөлтийн ажил эхэлж, нийт 31.72 км ЦДАШ, хоёр шинэ дэд станц, нэг дэд станцын өргөтгөлийн ажил төлөвлөгдсөн бөгөөд одоогоор 50 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.

Дархан-Мангирт чиглэлийн 110 кВ-ын нэг хэлхээт ЦДАШ-ын ажлын зургыг “Баясалтөгс” ХХК боловсруулж, барилга угсралтын ажлыг “Энх өглөө” ХХК 2023 оны 6 дугаар сарын 20-наас эхлүүлсэн. Одоогоор тулгуурын газардуулга, шилэн кабель холболтоос бусад ажил хийгдээд байна.

АЖИЛТНУУДЫН ТАВ ТУХЫГ НЭМЭГДҮҮЛСЭН ШИНЭ ЦАЙНЫ ГАЗАР АШИГЛАЛТАД ОРЛОО

Төвийн бүсийн салбар нь ажилтнуудын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор шинэ цайны газрыг 2026 оны 03-р сарын 03-ны өдөр албан ёсоор нээж, ашиглалтад орууллаа.

Өмнө нь склад, агуулахын зориулалтаар ашиглаж байсан байрыг бүрэн засварлан тохижуулснаар 40 хүнд зэрэг үйлчлэх хүчин чадалтай болсон байна.



УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР 110/35/6 КВ-ЫН СҮХБААТАР ДЭД СТАНЦЫН ХҮЧИН ЧАДАЛ НЭМЭГДҮҮЛЖ, ТОНОГЛОЛ ШИНЭЧИЛЭВ.



1965 онд анх 10 МВА хүчин чадалтайгаар ашиглалтад орсон 110/35/10 кВ-ын Сүхбаатар дэд станц 1989 онд нэмэлт трансформатор суурилуулснаар нийт 20 МВА хүчин чадалтай болж, 60 жилийн турш тасралтгүй ажилласан түүхтэй.

2024–2025 онд станцын өргөтгөл, шинэчлэлийн ажил өрнөж, 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийг I, II СШ болгон өргөтгөж, 35 кВ-ын ИХБ-ын таслууруудыг шинэчилж, шиний утсыг сольсноор дамжуулах чадлыг нэмэгдүүлэв. Мөн 210 МВА хүчин чадалтай байсан Т-1, Т-2 трансформаторуудыг 225 МВА болгож өргөтгөсөн нь станцын хүчин чадлыг 40 хувиар нэмэгдүүлэх чухал алхам боллоо.

ХБНГУ-ын (KfW)-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжсэн төслөөр трансформаторын таслуур, гүйдлийн трансформатор, реле хамгаалалтын системийг бүрэн шинэчилж, 6 кВ-ын I секцийн 10 ширхэг КYN28А маягийн вакуум таслуур бүхий ячейк суурилуулсан. Ингэснээр анхдагч болон хоёрдогч хэлхээний тоноглол орчин үеийн дэвшилтэд системээр хангагдаж, НМИ



хяналт удирдлагын бие даасан систем бий болсон.

Шинэчлэлийн үр дүнд реле хамгаалалт, автоматикийн найдвартай ажиллагаа эрс сайжирч, Сэлэнгэ аймаг болон Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн найдвартай байдал нэмэгдэв. Энэ нь бүс нутгийн хөгжил, үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагаанд томоохон хувь нэмэр оруулсан, үр өгөөж арвин төсөл болж байна.

ТЕХНИКИЙН АЛБАДУУДЫН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Компанийн техникийн албадуудын ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2026 оны 01-р сарын 15–28-ны өдрүүдэд сургалт зохион байгуулагдлаа.

Сургалт нь Туул дэд станцын дэргэдэх сургалтын полигоны талбайд болон албадын ажлын байранд зэрэг зохион байгуулан ажилтнуудын онолын мэдлэгийг бататгахын зэрэгцээ практик дадлага хийх боломжийг бүрдүүлсэн байна. Энэхүү сургалт нь тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах, реле хамгаалалт, автоматикийн системийн чадамжийг нэмэгдүүлэх, инженер техникийн ажилтнуудын ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болж өнгөрлөө.



системийн чадамжийг нэмэгдүүлэх, инженер техникийн ажилтнуудын ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болж өнгөрлөө.



ХОСМОГ СУРГАЛТЫН ОРЧИНД БОДИТ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭВ

“Өндөр хүчдэлийн техникч” мэргэжлээр хосмог сургалтыг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны хүрээнд Улаанбаатар салбарын Захиргаа, аж ахуйн алба болон Засварын албаны хамт олон Налайх, Дарханы Политехник коллежийн өндөр хүчдэлийн лабораторид

сургалтын зориулалттай макет хийж хүлээлгэн өглөө.

Эдгээр үзүүлэн самбар нь цахилгаан дамжуулах агаарын шугамын эд ангиудыг бодитоор харуулж, сургалцагчдад практик мэдлэг олгох боломжийг бүрдүүлсэн байна.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Илчбаян дэд станцын 110/10 кВ-н ил хуваарилах байгууламжийн бохирдолтой тоноглолуудад чангалгаа, цэвэрлэгээ үйлчилгээ, тохиргоо хийж гүйцэтгэсэн.

Налайх дэд станцын 10 кВ-н 9 нэр төрөл, Баянчандмань дэд станцын 12 нэр төрлийн таслуурт урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн.



ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

ШУГАМЫН ГЭМТЭЛ УСТГАХ ЗАСВАРЫН АЖЛУУД ХИЙГДЛЭЭ



Эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах зорилгоор 2026 оны эхний улиралд дараах гэмтэл устгалтын засварын ажлыг зохион байгуулан гүйцэтгэлээ.

- 143-р АШ-ын тулгуур №180-ын 3-р фазын дамжуулагч утас тасарч унасан гэмтлийг засварлаж, хэвийн ажиллагааг сэргээв.

- 110 кВ-ын Сайншанд болон 143-р АШ-д үзлэгээр илэрсэн гэмтлийг засварлаж, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангаж ажиллав.

- 262-р АШ-ын тулгуур №33-ын В фазын шлейфэнд төмөр утас тохогдсон гэмтлийг арилгаж, шугамын хэвийн ажиллагааг сэргээв.

РЕЛЕ ХАМГААЛАЛТ, АВТОМАТИК, ХЭМЖҮҮРИЙН ИНЖЕНЕРҮҮДИЙН СУРГАЛТ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



“ЭРЧИМ ХҮЧЭЭ ЗӨВ ХЭРЭГЛЭЖ, ЗӨНДӨӨ ХЭМНЭЭ” АЯНЫ ХҮРЭЭНД СУРАГЧДАД СУРГАЛТ, УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАВ

“Нийгмийн нөлөөллийн аян”-ы хүрээнд эрчим хүчний зөв хэрэглээ, хэмнэлтийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлах ажлууд үргэлжилж байна.

Багануур дүүрэг, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь аймгийн ерөнхий боловсролын 6 сургуулийн 35 бүлгийн нийт 1425 сурагчдад эрчим хүчний тухай ойлголт, хэмнэлтийн энгийн дадлуудын талаар мэдээлэл хүргэж, мөн “Эрчим хүчээ зөв хэрэглэж, зөндөө хэмнэе” сэдэвт рийл бичлэгийн уралдааныг Багануур дүүргийн ерөнхий боловсролын 10–12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулан шилдэг бүтээлийг шалгаруулсан байна.



Төв удирдлагаас Реле хамгаалалт, автоматик, хэмжүүр тоолуур, өндөр хүчдэлийн туршилт хэмжилтийн инженерүүд ажлын байрны сургалтыг Зүүн-Өмнөд бүсийн салбарт 2026 оны 3-р сарын 5, 6-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Сургалтын явцад компани болон салбарын тулгамдсан асуудал, сургалтын үр дүнг хэлэлцэж, дараах чиглэлээр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр санал нэгдэв. Үүнд:

- Компанийн хэмжээнд РХА, хэмжүүр, туршилтын ажилтнууд мэдээлэл солилцох цахим системийг нэвтрүүлж, тавил, схем болон бусад мэдээллийг байршуулах.

- РХА, хэмжүүр, туршилтын ажилтнуудын сургалтыг тогтмол зохион байгуулж, харилцан туршлага солилцох, нэг нэгнээсээ суралцах боломжийг бүрдүүлэх.

- Тусгаарлагдсан нейтральтай сүлжээг бага эсэргүүцлээр газардуулж, нэг фазын газардлагын богино залгааны гэмтлийг богино хугацаанд мэдэрч таслах чиглэлтэй хамгаалалтыг ажиллагаанд оруулах.

- РХА-н ерөнхий шаардлагад завсрын шүүгээ (МК)-тэй холбоотой заалт байдаггүй тул зураг төсөлд уг шаардлагыг тусгах.

Сургалтад компанийн хэмжээнд ажиллаж буй Реле хамгаалалт, автоматик, хэмжүүр тоолуур, өндөр хүчдэлийн туршилт хэмжилтийн ажилтнуудын 70 орчим хувь нь хамрагдсан бөгөөд нэг нэгнээсээ суралцаж, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл солилцож, шинэ ажилтнууд хоорондоо танилцан, ажлын холбоо тогтоосон нь сургалт боллоо.

“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ЗАХИРГАА, ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ ХООРОНД БАЙГУУЛСАН 2025-2026 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭГ ЦУВРАЛ БОЛГОН ХҮРГЭХ НЬ

Үргэлжлэл...

2.14. Бохирын үйлчлэгчид үндсэн цалингийн 15 хувиар нэмэгдэл олгоно. Энэхүү нэмэгдэл зөвхөн бохирын үйлчлэгчийн ажлын байранд ажиллах хугацаанд нь олгоно.

2.15. Компанийн оны “Хөдөлмөрийн аварга”-аар шалгарсан, хүндэт дэвтэрт бичигдсэн ажилтныг салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, “Салбарын тэргүүний ажилтан”-аар шалгарсан ажилтныг салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус шагнана.

2.16. Компанид үр бүтээлтэй ажилласан ажилтны нэг удаагийн шагналын хэмжээ нь салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшуулал байна. Энэхүү заалт нь 2.15 дахь хэмэгт хамаарахгүй.

2.17. Төрийн захиргааны төв байгууллагаас тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан ажилтанд сар бүр 15000 төгрөг олгоно.(Энэ заалт ахмад настан болон тахир дутуугийн группт байгаа хүмүүст нэгэн адил хамаарагдана)

2.18. Монгол Улсын төрийн дээд шагнал (Төрийн соёрхолт, Гавьяат ажилтан, Хөдөлмөрийн баатар)-аар шагнагдсан салбарын ажилтан, ахмад настанд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин хүртэл, “Хөдөлмөрийн баатар” цолоор шагнагдсан ажилтан, ахмад настанд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин хүртэл үржүүлсэнтэй тэнцэх нэг удаагийн мөнгөн урамшууллыг тус тус олгоно.

2.19. Эрчим хүчний яам, салбарын ҮЭ-ийн хорооноос хамтран олгож байгаа “Тэргүүний мастер” цол тэмдгээр шагнагдсан ажилтанд 100,000 төгрөгөөс доошгүй дагалдах урамшууллыг Үйлдвэрчний эвлэлийн хорооноос олгоно.

2.20. Эрчим хүчний салбарт удаан жил ажилласны нэмэгдлийг ажилласан хугацаанаас нь хамааруулан дараах хувь хэмжээгээр олгоно.

Тэтгэврээ тогтоолгон ажиллаж байгаа ажилтанд эрчим хүчний салбарт удаан жил ажилласны нэмэгдэл олгохгүй.

2.21. Компанийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад бодит хувь нэмэр оруулсан ажил төрлийн холбоотой дотоод,

гадаад улсын байгууллага, ажилтныг тэмдэглэлт ой, баяр ёслолын үед шагнаж урамшуулж болно.

ГУРАВ. АЖИЛТНУУДЫН МЭДЛЭГ, МЭРГЭЖИЛ БОЛОВСРОЛЫН ТАЛААР

3.1. Ажилтны мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах асуудлыг компанийн бизнес төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ. Үйлдвэрчний эвлэлийн хорооноос дэвшүүлсэн саналыг харгалзан үзнэ.

3.2. Компанийн санаачилгаар дотоод, гадаад улсад мэргэжил дээшлүүлэх дамжаанд суралцах, туршлага судлахаар үндсэн ажлаасаа түр чөлөөлөгдсөн ажилтанд энэ хугацаанд нь албан тушаалын үндсэн ба тарифт цалин, удаан жилийн нэмэгдлийг тус тус олгоно.

3.3. Ажилтны ажлын байрны сургалтыг ажил олгогчийн зүгээс зохион байгуулж, гарын авлага, техник хэрэгслээр хангана.

3.4. Дээд боловсрол эзэмшсэн ажилтнуудаас мэргэжлийн чиглэлээр аспирантур, докторантурт суралцаж, цаашид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлд гэрээний дагуу суралцах хугацааны төлбөрийг хариуцаж болно.

3.5. Их, дээд сургууль, коллежид суралцагчдаас хөдөө, орон нутагт ажиллах оюутныг шаардлагатай мэргэжлээр нээлттэй сонгон шалгаруулж, гэрээ байгуулан сургалтын төлбөрийн тодорхой хувийг компаниас хариуцаж болно.

3.6. Үйлдвэрлэл дээрх түр сургалтад хичээл заасан багш нарт цагийн 30,000 төгрөгийн хөлс олгоно. Зайлшгүй тохиолдолд компанийн ажилтнуудад хичээл заасан гадны байгууллагын багш нарт олгох хөлсийг гэрээ хэлцлийн журмаар тогтооно. Түгээмэл бус нарийн мэргэжлийг өвлүүлэн сургах ажлыг доктор, зөвлөх, мэргэшсэн инженер, мэргэжилтэн, мастер багш нараар удирдуулан ажлын байранд зохион байгуулж, тэдэнд цагийн хөлсийг 50,000 хүртэл төгрөгөөр бодож олгоно.

3.7. Эрчим хүчний салбарын хэмжээнд ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн зохион байгуулж, шинэ арга барил, ажлын туршлага, мэдээлэл солилцуулах арга хэмжээ авна.

3.8. Эрчим хүчний мэргэжлийн ажилтныг ажилд шинээр авахад:

- Эрчим хүчний мэргэжлээр их, дээд сургуулийг бакалавр болон бакалавраас дээш зэрэгтэй төгссөн бол 4 дүгээр зэргээр,

- Эрчим хүчний мэргэжлээр их, дээд сургуулийг дипломын инженерээр, эсвэл коллеж төгссөн бол 3 дугаар зэргээр,

- Эрчим хүчний мэргэжлээр МСУТ болон курс төгссөн ажилтныг дагалдангаар ажиллах хугацаанд 2 дугаар зэргээр, шалгалтаа хугацаандаа өгч тэнцсэн тохиолдолд 3 дугаар зэргээр тус тус цалинжуулна.

Эрчим хүчний инженерийн мэргэжил эзэмшээд монтоороор ажиллаж байгаа ажилтан мэргэжлийн зэргийг ахиулах тохиолдолд “Эрчим хүчний үйлдвэрүүдийн ИТА, ажилтнуудын дунд сургалт явуулах үндсэн дүрэм”-ийг баримтлан зэргийн шалгалт өгч, зэргийг комиссын шийдвэрийн дагуу олгоно.

3.9. Компани жил бүр нийт ажилтны 30-аас доошгүй хувийг сургалтад хамруулж, нийт зардлын 0.5 доошгүй хувийг сургалтад зарцуулахаар төлөвлөж хэрэгжүүлнэ.

3.10. Хосмог сургалтын тогтолцоог компанийн хэмжээнд хэрэгжүүлэх дадлагажуулагч багшид гэрээг үндэслэн үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдэл олгоно.

3.11. Шинээр батлагдсан хөдөлмөрийн харилцаа, хүний эрх болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хуулиудыг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороо хамтран зохион байгуулна.

3.12. Компанийн хэмжээнд дамжуулах сүлжээний шугам, тоноглолын найдвартай ажиллагааны түвшин, засвар, ашиглалтын ажлын чанар, эдийн засгийн үр ашиг, ажлын хариуцлага, бүтээмж, сахилга батыг дээшлүүлэх, цахилгаан эрчим хүчийг хэмнэх, дамжуулалтын алдагдлыг бууруулах, ХАБЭА-г хангах, осол, технологийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажилтнуудад эерэг хандлага, ажлын соёл төлөвшүүлэх, удирдлага, менежер, ажилтнуудын багаар ажиллах сэтгэлгээг бий болгох, бүтээлч санаачилгыг нэвтрүүлэх зэрэгт чиглэсэн уралдаан, ажил мэргэжлийн тэмцээнийг зохион байгуулж, шалгаруулах, урамшуулах ажлыг жил бүр зохион байгуулна.

ДӨРӨВ. АЖИЛТНЫ НИЙГМИЙН АСУУДЛЫН ТАЛААР

4.1. Ажилтанд өдрийн хоолны үнийг ажлын өдөрт 15,000 төгрөгөөр бодож, түүний 60 хувиар хөнгөлөлт олгоно.

4.2. Ажилтнуудад халаалтын улирлын хөнгөлөлтийг жилд нэг удаа 100,000 төгрөг

олгоно. Тус хөнгөлөлтийн хэмжээг цаашид нэмэгдүүлэх бодлого баримтална.

Нэг өрхийн хэд хэдэн гишүүн компанид ажилладаг бол зөвхөн нэг гишүүнд хөнгөлөлт олгоно. Энэхүү заалт ахмадууд болон групптэй хүмүүс, жирэмсний, амаржсаны амралттай болон хүүхэд асарч буй эхчүүдэд нэгэн адил хамаарна.

4.3. Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах үүднээс рашаан, сувилалд сувилуулж амарсны зардлыг улсын чанартай магадлан итгэмжлэгдсэн рашаан, сувиллын илгээх бичгийг үндэслэн ажилтанд 100,000 төгрөгийг нэг удаа олгох ба зардлыг Захиргаа болон Үйлдвэрчний эвлэлийн хороо хувааж гаргана. Энэхүү заалт мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрийн осолд орсон групптэй хүмүүс, хүүхэд асрах чөлөөтэй эхчүүдэд нэгэн адил хамаарна.

4.4. Төв удирдлага, салбарын ажилтанд ажлын өдөр ажиллахаар ирэх, ажлаас буцахад 2000 төгрөгөөр тооцож, унааны хөнгөлөлт олгоно. Ажилтнуудад компанийн унаагаар үйлчилж байгаа тохиолдолд энэхүү заалт хамаарахгүй.

4.5. Ажилтны хууль ёсны (төрсөн болон үрчилж авсан) эцэг эх, эхнэр, нөхөр, хүүхэд нь нас барсан тохиолдолд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буцалтгүй мөнгөн тусламжийг байгууллага үзүүлнэ. (Нэг байгууллагад гэр бүлийн болон ах, дүү хэд хэдэн хүн ажилладаг бол зөвхөн нэг хүнд нь олгоно). Үйлдвэрчний эвлэлийн хороо 200,000 төгрөг олгоно.

4.6. Өөрийнх нь өргөдлийг үндэслэн ар гэрт нь зайлшгүй мөнгөн тусламж үзүүлэх шаардлагатай бол 3 хүртэлх насны хүүхдээ асарч буй эцэг, эхчүүд болон тухайн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд, тахир дутуугийн группэд орсон хүмүүс, хорт хавдар, хүнд хэлбэрийн цус харвалт, мэс засалд орсон ажилтнуудад эмнэлгийн магадлагаа, холбогдох баримт бичгийг үндэслэн өрх толгойлсон эмэгтэйчүүд, эрчүүд, бүтэн өнчин үлдсэн айлын нэг хүүхдэд тухайн өрхийн нэг хүнд оногдох орлого нь Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос баталсан хүн амын амьжиргааны доод түвшний хэмжээнд хүрэхгүй байгаа нөхцөлд жилд нэг удаа салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлнэ.

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ

“ТӨВИЙН БҮСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ”

1) ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ 2025 ОН

▲ 32 дэд станцын зураг төсөл боловсруулж, баталгаажуулсан.

▲ 34 тэрбум төгрөгийн өртөг бүхий анхдагч хэлхээний 849 ширхэг, хоёрдогч хэлхээний 231 ширхэг тоноглол, 26 км гаруй кабель, дагалдах материал нийлүүлэгдэж, гааль болон НӨАТ-аас чөлөөлөгдсөн.

▲ Налайх, Баянчандмань, Хархорин, Баруунхараа зэрэг нийт 21 дэд станцад 426 ширхэг анхдагч, 61 ширхэг хоёрдогч тоноглолыг шинэчилсэн.

2) ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ 2026 ОН

▲ Хоёрдогч хэлхээний таслуур, трансформатор, ВСУ болон реле хамгаалалтын тоноглолуудыг нийлүүлж, татварын чөлөөлөлт хийсэн.

▲ Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Арвайхээр зэрэг 15 дэд станцад барилга угсралтын ажил эхэлж, нийт 404 ширхэг анхдагч, 49 ширхэг хоёрдогч тоноглолыг шинэчлэхээр төлөвлөсөн.

▲ 220 кВ-ын ИХБ-4, Улаанбаатар, Дархан,

Эрдэнэт дэд станцуудад алсын хяналт удирдлагын НМИ систем нэвтрүүлж, Улаанбаатар дэд станцыг орчин үеийн дижитал дэд станц болгон шинэчилнэ.

3) ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР ГАРАХ ҮР ДҮН

ЦДҮС ТӨХК-ийн 220, 110 кВ-ын 32 дэд станцын ажиллагаанд байгаа ашиглалтын хугацаа хэтэрсэн, дотоод хэрэгцээний ЦЭХ-ний зарцуулалт их, ашиглалтаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой сөрөг нөлөө үзүүлдэг тосон таслуур, насжилт өндөртэй, технологийн хувьд хоцрогдсон механик реле хамгаалалт, автомат удирдлагын тоног төхөөрөмжүүдийг орчин үеийн дэвшилтэд технологи бүхий тоног төхөөрөмжөөр бүрэн шинэчлэх замаар дараах гол үр дүнд хүрнэ. Үүнд:

▲ 110 кВ-ын тосон таслуур 49ш, ОД 22ш, КЗ хуурай таслуурыг бүрэн шинэчилж ашиглалтаас гаргаснаар компанийн хэмжээнд 110 кВ-ын таслуурууд бүгд Элегаз таслуур болно.

▲ 35 кВ-ын 108ш тосон таслуурыг шинэчилж ашиглалтаас гаргаснаар компанийн хэмжээнд 35 кВ-ын

таслуурууд бүгд вакуум таслуур болно.

▲ 35 кВ, 110 кВ-ын тосон таслуурыг элегаз, вакуум таслуур болгож шинэчилснээр дэд станцуудын дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний хэрэглээ буурч, эрчим хүчний үр ашигтай хэмнэлттэй хэрэглээг нэмэгдүүлнэ. Технологийн хувьд хоцрогдсон, засвар хийх сэлбэг хэрэгслийн нөөцгүй болсон насжилт өндөртэй тоноглолын ашиглалтаас шалтгаалж гарах гэмтэл, тасралт, аваарийн эрсдэлийг бууруулна.

▲ Нийт 323 тонн тос агуулсан тосон таслууруудыг ашиглалтаас буулгаснаар тосон тоноглолын ашиглалтаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой сөрөг нөлөөллийг бүрэн арилгана. Мөн Монгол улсын Стокгольмын конвенциар хүлээсэн үүрэг Полихлорт бифенил агуулсан цахилгаан тоног төхөөрөмжийн хэрэглээг 2025 онд бүрэн зогсоох, 2028 он гэхэд байгаль орчинд ээлтэй аргаар устгаж дуусгах үүргийг биелүүлнэ.


▲ Орчин үеийн ухаалаг дэвшилтэд автоматжуулалтын системтэй нийцэж ажиллах технологийн шаардлагыг

хангахгүй байгаа хоёрдогч хэлхээ бүрдүүлж байгаа механик реле хамгаалалт, автоматикийн төхөөрөмжүүд бүрэн шинэчлэгдэнэ.

▲ Дэд станцуудын механик РХА-ыг бүрэн шинэчилж, Улаанбаатар дэд станцыг дижитал дэд станц болгож, 220 кВ-ын 4 дэд станцад алсын зайн хяналт удирдлагын /НМИ/ системийг нэвтрүүлснээр ЦДҮС ТӨХК-ийн АЛСЫН ХАРАА ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ “УХААЛАГ СҮЛЖЭЭ” болох техник технологийн суурь нөхцлийг бүрдүүлнэ.

▲ ЦДҮС ТӨХК-ийн “ЭРХЭМ ЗОРИЛГО” болох аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологийг ашиглан цахилгаан эрчим хүчийг найдвартай, үр ашигтай дамжуулах зорилгод хүрэхэд бодитой хувь нэмэр оруулна. Төвийн бүсийн эрчим хүчний системийн хэрэглэгчид болох 666,349 айл өрх, 67,398 аж ахуйн нэгжийн цахилгаан хангамжийн тасралтгүй, найдвартай байдал дээшилнэ.

“ДОМОГТ ИНЖЕНЕР” НОМ ХЭВЛЭГДЭН ГАРЛАА



Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Ахмадын хорооноос Монгол Улсын эрчим хүчний салбарын нэрт зүтгэлтэн, гавьяат ажилтан инженер Намсрайн Тогоогийн мэндэлсний 100 жилийн ойд зориулан “Домогт инженер” номыг эмхэтгэн бүтээв. Номыг эрчим хүчний салбарын өндөр настнууд, хөдөлмөрийн баатар, гавьяатуудын санаачилгад тулгуурлан эрхлэн гаргалаа.

Монгол Улсын эрчим хүчний салбарын хөгжил, төлөвшил нь зөвхөн техник технологийн дэвшил төдийгүй түүнийг бүтээгч, тууштай зүтгэгч эрхэм хүмүүсийн оюун ухаан, хөдөлмөр зүтгэлээр бүтсэн бахархалт түүх билээ. Энэ их хөгжлийн замналд өөрийн амьдрал, хөдөлмөр зүтгэлээ зориулсан эрхэм хүмүүсийн нэг нь Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, домогт инженер Намсрайн Тогоо мөн.

Н.Тогоо инженер бага наснаасаа өнчрөлийн зовлонг туулж, өсвөр насандаа мэдлэг боловсролын төлөө тэмүүлэн, идэр залуудаа 1940–1950 оны эрчим хүчний салбарын техникийн хүндрэл бэрхшээлийг даван туулсан хөдөлмөрч нэгэн байв. Тэрээр 1960-аад оноос эхлэн инженерийн сэтгэлгээ, алсын хараагаараа эрчим хүчний салбарын улс орны хөгжилд эзлэх тэргүүлэх ач холбогдлыг төр, засгийн түвшинд ойлгуулж, улс төрийн бодлого, хөгжлийн хөтөлбөрт хүртэл дэвшүүлж чадсан юм.

Эрчим хүчний салбарын суурь нь Эрчим хүчний үйлдвэрүүдийг удирдах газраас эхлэн Төвийн эрчим хүчний систем, ТЭХҮГЯ, ТЭХҮЯ, Түлш, эрчим хүчний Эрдэм шинжилгээ, зураг төслийн институт болон өргөжин салбарын бодлогыг шинжлэх ухаанчаар төлөвлөж бүтээн байгуулалтыг өрнүүлж дотоод, гадаадын техникийн мэргэжлийн сургууль, их дээд боловсролын байгууллагуудад боловсон хүчнийг төлөвлөгөөтэй бэлтгэж, үйлдвэрлэл, ашиглалт, угсралт, хангалт, тээвэр механизмын иж бүрэн баазтай эрчим хүчний салбарын томоохон тогтолцоог бүрдүүлсэн нь маргашгүй үнэн.

Түүний нэгэн жарны турш тасралтгүй хөдөлмөрлөсөн зүтгэл нь Монгол Улсыг хөдөө аж ахуйн орноос аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болон хөгжих түүхэн үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулсан билээ. Аугаа удирдагч Ю.Цэдэнбал даргын дэвшүүлсэн хөгжлийн бодлогын жишгийг баримтлан, өөрийн мэдлэг чадвар, удирдах арга барилаа дайчлан ажилласан нь түүнийг зөвхөн салбарын төдийгүй улс орны хөгжлийн нэрт зүтгэлтэн болгосон билээ.

Н.Тогоо сайдын гавьяа хөдөлмөрийг эрчим хүчний салбарынхан төдийгүй бусад салбарын мэргэжилтнүүд ч өндрөөр үнэлж, “Тогоо сайд”, “Домогт инженер”, “Эрчим хүчний загалмайлсан эцэг” хэмээн хүндэтгэн өргөмжилдөг.

Монгол Улсын эрчим хүчний салбарын нэрт зүтгэлтэн, гавьяат ажилтан

инженер Намсрайн Тогоогийн мэндэлсний 100 жилийн ойд зориулан энэхүү “Домогт инженер” номыг эмхэтгэн бүтээв. Номыг эрчим хүчний салбарын өндөр настнууд, хөдөлмөрийн баатар, гавьяатуудын санаачилгад тулгуурлан Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Ахмадын хорооноос эрхлэн гаргалаа.

Энэхүү бүтээлд олдоц хомс ном, сонин, гэрэл зураг, архивын материалуудаас түүвэрлэн ашиглаж, түүнтэй хамт ажиллаж явсан хүмүүсийн сэтгэгдэл, дурсамжийг нэгтгэн оруулсан болно.

“Домогт инженер” ном нь зөвхөн нэг хүний амьдралын замнал төдийгүй Монгол Улсын эрчим хүчний салбарын хөгжлийн нэгэн түүхэн үеийн бодит хөрөг болон үлдэх учиртай.

ТӨРИЙН ДЭЭД ОДОНГООР ШАГНАГДЛАА



Төвийн бүсийн салбарын ахмад ажилтан Г.Гүнжий нь 1963 оны 3-р сарын 30-нд Сэлэнгэ аймгийн Ерөө суманд төрсөн. 1981-1985 онд Дархан-Уул аймгийн Политехникумд суралцаж, цахилгааны техникч мэргэжлээр төгссөн бөгөөд Эрчим хүчний яамны томилгоогоор Дархан-Сэлэнгийн цахилгаан шугам сүлжээний газрын харьяа Ерөө салбарын Бугант хэсэгт ээлжийн монтероор ажлын гараагаа эхлүүлсэн.

Ерөө салбарт ажиллах хугацаандаа тэрээр салбарын дарга, хэсгийн монтер, гэрлийн байцаагч, техникч, мастер зэрэг албан тушаалд ажиллаж, ЦДҮС ТӨХК-ийн Төвийн бүсийн салбарын Бугант, Толгойт дэд станцын мастераар нийт 29 жилийн турш тасралтгүй хөдөлмөрлөсөн байна.

Түүнийг Эрчим хүчний салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан гавьяаг нь үнэлж, 2026 оны 3-р сарын 27-ны өдөр төрийн дээд шагнал болох Алтан гадас одонгоор шагналаа.

Тэрээр 1985 оноос эхлэн Дархан-Сэлэнгийн цахилгаан шугам сүлжээний газар болон ЦДҮС ТӨХК-ийн Төвийн бүсийн салбарын 110/6 кВ-ын Бугант, Толгойт дэд станцын найдвартай ажиллагааг хангах, параметруудад тогтмол хяналт тавих, ээлжийн хугацаанд гарсан гэмтэл зөрчлийг богино хугацаанд арилгах, тоноглолын найдвартай ажиллагааг дээшлүүлэх, хэрэглэгчдийг чанартай цахилгаанаар тасралтгүй хангах зорилгыг тууштай хэрэгжүүлж ирсэн.

Г.Гүнжий нь тоног төхөөрөмжийн ашиглалтын түвшинг дээшлүүлэх, станцын тохижилт, соёлжилтод онцгой анхаарч, сар бүр тодорхой ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг байсан. Мөн спортын уралдаан тэмцээнд идэвхтэй оролцож, шатрын спортоор хичээллэн алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн тамирчин байжээ.



АХМАД ИНЖЕНЕРИЙН ҮНЭТ ЗӨВЛӨГӨӨ

Ахмадын хороо, Судалгаа хөгжил төлөвлөлтийн хэлтэс хамтран Монголын эрчим хүчний салбарын ууган мэргэжлийн инженерүүдийн нэг, Москвагийн Эрчим хүчний дээд сургуулийг 1965 онд төгссөн С.Жамъянжав гуайг хүндэтгэн урьж, ЦДҮС ТӨХК-ийн удирдлагын бүрэлдэхүүнтэй мэргэжлийн зөвлөгөөний уулзалт зохион байгууллаа.

С.Жамъянжав гуай нь “Өндөр хүчдлийн цахилгаан тоноглолын хэмжилт, туршилт, хэт хүчдлийн хамгаалалт”-аар мэргэшсэн бөгөөд Монголын эрчим хүчний салбарын хөгжлийн түүхэнд үнэтэй хувь нэмэр


орүүлсан ахмад инженер юм. Тэрбээр 2002 онд инженер, эрдэмтдийн багийн хамтаар боловсруулсан “Монгол Улсын Эрчим хүчний нэгдсэн сүлжээний хөтөлбөр”-ийг Улсын Их Хурлын 23 дугаар тогтоолоор батлуулж, салбарын бүтээн байгуулалтын суурийг тавьсан юм.

Уулзалтын үеэр тэрээр Монголын эрчим хүчний системд усан цахилгаан станцын тохируулгыг онцгойлон анхаарч, судалгаа төлөвлөлтөд тусгахыг зөвлөв. Мөн ЦДҮСК-ийн удирдлагаас танилцуулсан “Эрчим хүч-4” төсөл, Мандалговь-Арвайхээрийн 220 кВ-ын 287 км шугам, дэд станцын

барилга, Багануур-Чойрын 220 кВ-ын шугамын өргөтгөл, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг сонсож, инженерийн багийн чадамж, хамт олны бүтээмжид сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийллээ.

“Бие махбодь минь хэдэн жилийн эрчмээр цэнэглэгдлээ” хэмээн урам зоригийн сайхан үг хэлсэн нь уулзалтад оролцогчдын сэтгэлийг сэргээж, салбарын ирээдүйд итгэл өгсөн онцгой мөч байлаа.





СУРГАЛТ БҮТЭЭМЖ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС



Хэлтсийн дарга Д.Хүрэл, хэлтсийн ахлах бөгөөд сургалт бүтээмжийн инженер П.Аюушбилэг, сургалтын инженер А.Нямсүрэн, бүтээмжийн инженер Б.Цэцэгмаа, хамтын ажиллагааг мэргэжилтэн Х.Замбага, хэвлэл мэдээллийн мэргэжилтэн Б.Энхсанаа

ӨРГӨН ТЭЭВЭРЛЭХ МЕХАНИЗМЫН ООСОРЛОГЧ ДОХИОЧИН, КРАНААР АЧАА ШИЛЖҮҮЛЭХ ҮЕЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАРИУЦАГЧ НАРЫН ЭРХ ОЛГОХ, СУНГАХ СУРГАЛТАД АЖИЛТНУУДАА ХАМРУУЛЛАА



“Өргөн тээвэрлэх механизмын оосорлогч дохиочин, кранаар ачаа шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагааг хариуцагч нарын эрх олгох, сунгах” сургалтад хөтөлбөрийн дагуу компанийн нийт 172 ажилтан хамрагдав.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГАЖУУЛАГЧ БАГШИЙН СУРГАЛТАД 68 АЖИЛТАН ХАМРАГДЛАА

“Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг” (GIZ)-ээс хэрэгжүүлж буй “Монгол Улсын Тогтвортой эрчим хүчний чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд зохион байгуулагдсан “Үйлдвэрлэлийн дадлагжуулагч багш”-ийг чадавхжуулах, мэргэшүүлэх 4 удаагын сургалтанд компанийн хэмжээнд нийт 68 ажилтан хамрагдаж дадлагжуулагч багшийн сертификат авчээ.



Компанийн 2026 оны сургалтын нээгдсэн төлөвлөгөө, Гүйцэтгэх захирлын 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан “Мэргэшлийн зэрэг дэв олгох сургалтад сонгон шалгаруулах, сургалтын үр дүнг тооцож, нэмэгдэл хөлс олгох журам”-ын болон Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/37 тоот тушаалаар батлагдсан “Эрчим хүчний салбарын мэргэжилтнүүдэд мэргэшлийн зэрэг олгох журам”-ын шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн зөвлөх инженерийн сургалтад жил бүр ажилтнуудыг бэлтгэдэг.

КОМПАНИЙН ХЭМЖЭЭНД 47 ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР БАЙНА



Судалгаа, хөгжил, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Лхагвадэмбэрэл



Баруун бүсийн салбарын ерөнхий инженер Г.Чойжил



Улаанбаатар салбарын дарга Д.Будхүү




Засвар зохицуулалтын хэлтсийн ахлах, шугам засварын инженер С.Ариунбат



Төвийн бүсийн салбарын Реле хамгаалалт, автоматик, хэмжилт, туршилтын албаны дарга М.Чулуунбаатар

АЖИЛТНУУДЫН ХУВЬ ХҮН БОЛОН МЭРГЭЖЛИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛД ЗОРИУЛСАН “90/10” ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ БАТЛАГДЛАА



90/10 зарчим гэдэг нь ажилтан ажлын байранд ажлын цагийн 90 хувийг үндсэн ажилдаа зарцуулах бөгөөд 10 хувийг өөрийгөө хөгжүүлэхэд зарцуулахад хувь хүний болон мэргэжлийн өсөлт хөгжилд зориулсан зориулсан зарчим юм.

Компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/47 дугаар тушаалаар “90/10” зарчмыг хэрэгжүүлэх журам шинээр батлагдаж, мөн журамд заасны дагуу хэлтэс, салбарууд 2026 оны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.

“ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭ” СОНИНЫ РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий редактор: Б.Эрхэмзаяа (Ерөнхий инженер)
Эх бэлтгэгч, дизайнер: Б.Энхсанаа (Сургалт бүтээмж, хамтын ажиллагааны хэлтсийн хэвлэл мэдээллийн мэргэжилтэн)
Редакцийн гишүүд: Л.Дарамбазар (Ахмадын хорооны дарга)
П.Аюушбилэг (Сургалт бүтээмж, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах бөгөөд сургалт бүтээмжийн инженер)

Б.Цацрал (Захиргаа удирдлагын хэлтсийн ахлах бөгөөд хүний нөөцийн мэргэжилтэн)
Б.Батчулуун (Хяналт мониторингийн хэлтсийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер)
Б.Лхагвадэмбэрэл (Судалгаа хөгжил, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Б.Эрдэнэбаяр (Судалгаа хөгжил, төлөвлөлтийн хэлтсийн орчуулагч)
Ш.Аюурзана (Мэдээлэл технологийн хэлтсийн ахлах бөгөөд системийн инженер)